

**ЛИФТ УГСРАХ ТЕХНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН  
ТЕСТЫН АСУУЛТУУД****1. Дор бичсэн хэмжүүрийн аль нь лифтийг угсарсан чанарыг илэрхийлэх вэ?**

1. Электрон удирдлага нь стандарт функцээс илүү олон функцийг гүйцэтгэж байна
2. Түүгээр зорчиход мэдрэгдэх дуу, чичргээ
3. Хурд хязгаарлагч нь хоёр талдаа ажилладаг
4. Баригч барихад огцом биш аажим зөөлөн барьж байна

Хариу 2

**2. Дор бичсэн хэмжүүрийн аль нь лифтийг угсарсан чанарыг илэрхийлэх вэ?**

1. Лифтийн нийт эдлэгдэх хугацаа
2. Хурд хязгаарлагч нь хоёр талдаа ажилладаг
3. Баригч барихад огцом биш аажим зөөлөн барьж байна
4. Зам төмөр нь хамгийн дээд зэрэглэлийн өнгөлгөөтэй хийгдсэн байна

Хариу 1

**3. Дор бичсэн хэмжүүрийн аль нь лифтийг угсарсан чанарыг илэрхийлэх вэ?**

1. Хурд хязгаарлагч нь хоёр талдаа ажилладаг
2. Баригч барихад огцом биш аажим зөөлөн барьж байна
3. Зам төмөр нь хамгийн дээд зэрэглэлийн өнгөлгөөтэй хийгдсэн байна
4. Түүгээр зорчиход мэдрэгдэх элдэв цохилт, чимээ
5. Цахилгааны хүчдэлийн хэлбэлзлэл болон фаз тасрахаас хамгаалах хэрэгсэлтэй

Хариу 4

**4. Дор бичсэн хэмжүүрийн аль нь лифтийг угсарсан чанарыг илэрхийлэх вэ?**

1. Башмак нь тохируулдаг хийцтэй байна
2. Цахилгаан энергийн хэмнэлттэй хөдөлгүүр тавьсан
3. Түүгээр зорчиход мэдрэгдэх чихраа, доргио
4. Тог тасарсан үед автоматаар хамгийн ойр зогсоол дээрээ очиж зогсоод зорчигчоо буулгадаг

Хариу 3

**5. Дор бичсэн хэмжүүрийн аль нь лифтийг угсарсан чанарыг илэрхийлэх вэ?**

1. Угсралтын чанар нь түүгээр зорчиход мэдрэгдэх дуу, чичргээ, мөн түүний эдлэгдэх явцдаа ихсэх байдал, лифтийн нийт эдлэгдэх хугацаа
2. Цахилгаан энергийн хэмнэлттэй хөдөлгүүр тавьсан
3. Тог тасарсан үед автоматаар хамгийн ойр зогсоол дээрээ очиж зогсоод зорчигчоо буулгадаг
4. Цахилгааны хүчдэлийн хэлбэлзлэл болон фаз тасархаас хамгаалах хэрэгсэлтэй

Хариу 1

**6. Лифтийг чанартай угсрах нь ямар ач холбогдолтой вэ? Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Түүний эд ангийн элэгдэх нь бага
2. Илүү хүнд ачаа даах чадвартай болдог
3. Металл хийц нэмэгдэл ачаалал деформаци, гулзайлт өгөх нь багасна
4. Угсралтаас үүдэлтэй зүй бус саатал гарахгүй
5. Лифтийн ашиглагдах хугацаа уртасдаг

Хариу 2

**7. Лифтийг чанартай угсрах нь ямар ач холбогдолтой вэ? Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хаалганы автомат түгжээ аюулгүй найдвартай болдог
2. Түүний эд ангийн элэгдэх нь бага
3. Металл хийц нэмэгдэл ачаалал деформаци, гулзайлт өгөх нь багасна
4. Угсралтаас үүдэлтэй зүй бус саатал гарахгүй
5. Лифтийн ашиглагдах хугацаа уртасдаг

Хариу 1

**8. Лифтийг чанартай угсрах нь ямар ач холбогдолтой вэ? Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Түүний эд ангийн элэгдэх нь бага
2. Металл хийц нэмэгдэл ачаалал деформаци, гулзайлт өгөх нь багасна
3. Бүхээг унах аюулгүй болдог
4. Угсралтаас үүдэлтэй зүй бус саатал гарахгүй
5. Лифтийн ашиглагдах хугацаа уртасдаг

Хариу 3

**9. Лифтийг чанартай угсрах нь ямар ач холбогдолтой вэ? Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Түүний эд ангийн элэгдэх нь бага
2. Металл хийц нэмэгдэл ачаалал деформаци, гулзайлт өгөх нь багасна
3. Угсралтаас үүдэлтэй зүй бус саатал гарахгүй
4. Хурд хязгаарлагч хоёр талдаа ажиллах боломжтой болдог
5. Лифтийн ашиглагдах хугацаа уртасдаг

Хариу 4

**10. Лифтийг чанартай угсрах нь ямар ач холбогдолтой вэ? Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Түүний эд ангийн элэгдэх нь бага
2. Металл хийц нэмэгдэл ачаалал деформаци, гулзайлт өгөх нь багасна
3. Угсралтаас үүдэлтэй зүй бус саатал гарахгүй
4. Лифтийн ашиглагдах хугацаа уртасдаг
5. Буфер бүхээгийг найдвартай зогсоох чадвартай болдог

Хариу 5

**11. Лифтийг угсрахын өмнө бэлтгэл ажлыг хангах ёстой. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Лифт угсрах ажилчдыг шалгаруулж авна
2. Угсралт хийх хонгил, машины өрөө зургийн дагуу, чанартай хийгдсэнд анхаарах хэрэгтэй. Хэрэв энд ямар нэг алдаа байвал заавал засуулж байж ажлаа эхлэхийг зөвлөж байна. Ажлын явцад засна гэдэг нь ажилд саадтай байхаас гадна ажлын чанарт нөлөөлдөг
3. Хувцас солих, лифтийн эд ангийг хадгалах өрөөнүүдийг барилгын талтай ярилцан шийдвэрлэж, боломжийн хэмжээндээ тохижуулсан байх хэрэгтэй. Тохижуулна гэдэг нь гарын доорх, барилгын хаягдал материалаар сандал ширээ, өлгүүр тавиур гэх мэт зүйлсийг хийж тавих, цоож, түгжээтэй болгохыг хэлнэ
4. Хэрэглэгдэх багаж, хэрэгсэл, хангамжийн материал, угсралтын зураг, заавар, лифт угсрах график төлөвлөгөөгөө бэлдэн ажлын өрөөндөө хадах, байрлуулах

Хариу 1

**12. Лифтийг угсрахын өмнө бэлтгэл ажлыг хангах ёстой. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хувцас солих, лифтийн эд ангийг хадгалах өрөөнүүдийг барилгын талтай ярилцан шийдвэрлэж, боломжийн хэмжээндээ тохижуулсан байх хэрэгтэй. Тохижуулна гэдэг нь

гарын доорх, барилгын хаягдал материалаар сандал ширээ, өлгүүр тавиур гэх мэт зүйлсийг хийж тавих, цоож, түгжээтэй болгохыг хэлнэ

**2. Механикуудаа мэргэжлийн сургалтанд хамруулна**

3. Хэрэглэгдэх багаж, хэрэгсэл, хангамжийн материал, угсралтын зураг, заавар, лифт угсрах график төлөвлөгөөгөө бэлдэн ажлын өрөөндөө хадах, байрлуулах

4. Үйлдвэрээс ирсэн лифтийн эд ангиудын хайрцагийг эргүүлж битүүмжлэх боломжтойгоор эвтэйхэн задалж ирсэн эд анги эвдрэлгүй бүтэн байгаа эсэх, тоо ширхэг нь бүрэн эсэх, эд ангийн хийцийн онцлог, урьдынхаас өөрчлөлт байгаа эсэхийг нягталж үзээд шаардлагтай заримыг ажлын өрөөндөө оруулаад үлдсэнийг эргүүлж битүүмжлэн хадаад орхино

Хариу2

**13. Лифтийг угсрахын өмнө бэлтгэл ажлыг хангах ёстой. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хэрэглэгдэх багаж, хэрэгсэл, хангамжийн материал, угсралтын зураг, заавар, лифт угсрах график төлөвлөгөөгөө бэлдэн ажлын өрөөндөө хадах, байрлуулах

2. Үйлдвэрээс ирсэн лифтийн эд ангиудын хайрцагийг эргүүлж битүүмжлэх боломжтойгоор эвтэйхэн задалж ирсэн эд анги эвдрэлгүй бүтэн байгаа эсэх, тоо ширхэг нь бүрэн эсэх, эд ангийн хийцийн онцлог, урьдынхаас өөрчлөлт байгаа эсэхийг нягталж үзээд шаардлагтай заримыг ажлын өрөөндөө оруулаад үлдсэнийг эргүүлж битүүмжлэн хадаад орхино

**3. Угсралт дээр ажиллах туслах ажилчдаа мэргэжлийн аттестатчилалд хамруулна**

4. Уг лифтийг угсрах зураг, зааврыг судлаад, угсрах баг дотроо зөвлөлдөөд, лифтийг хэрхэн угсрах, аюулгүй ажиллах сургалт, зааварчилга явуулна

5. Лифт угсрах ажилчдад болон орчин тойрондоо аюулгүй ажиллах арга хэмжээг авна

Хариу 3

**14. Лифтийг угсрахын өмнө бэлтгэл ажлыг хангах ёстой. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Угсрах график төлөвлөгөөгөө бэлдэн ажлын өрөөндөө хадах, байрлуулах

**2. Ирсэн эд ангийн бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгаад эвдэрч гэмтсэн хэсгийг угсралт эхлэхээс өмнө засаж бэлэн болгоно**

3. Уг лифтийг угсрах зураг, зааврыг судлаад, угсрах баг дотроо зөвлөлдөөд, лифтийг хэрхэн угсрах, аюулгүй ажиллах сургалт, зааварчилга явуулна

4. Лифт угсрах ажилчдад болон орчин тойрондоо аюулгүй ажиллах арга хэмжээг авна

Хариу 2

**15. Лифтийг угсрахын өмнө бэлтгэл ажлыг хангах ёстой. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Үйлдвэрээс ирсэн лифтийн эд ангиудын хайрцагийг эргүүлж битүүмжлэх боломжтойгоор эвтэйхэн задалж ирсэн эд анги эвдрэлгүй бүтэн байгаа эсэх, тоо ширхэг нь бүрэн эсэх, эд ангийн хийцийн онцлог, урьдынхаас өөрчлөлт байгаа эсэхийг нягталж үзээд шаардлагтай заримыг ажлын өрөөндөө оруулаад үлдсэнийг эргүүлж битүүмжлэн хадаад орхино

2. Уг лифтийг угсрах зураг, зааврыг судлаад, угсрах баг дотроо зөвлөлдөөд, лифтийг хэрхэн угсрах, аюулгүй ажиллах сургалт, зааварчилга явуулна

3. Лифт угсрах ажилчдад болон орчин тойрондоо аюулгүй ажиллах арга хэмжээг авна

**4. Хөдлмөр хамгааллын хувцсыг шинээр авч өгч, түүнд компанийн эмблемийг хадаж, барилга дотор ажиллаж байгаа олон байгууллагын ажилчдаас ялгагдах онцлогтой болгоно**

Хариу 4

**16. Угсралт чанартай байхын тулд үйл ажиллагаандаа дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Тухайн лифт угсардаг байгууллага нь өөртөө угсрах ажлын чанарыг шалгах системийг бий болгосон байх шаардлагатай байдаг
2. Аливаа хоёр эд ангийг хооронд нь угсарч бооход заавал ямар нэг хэмжилт хийгддэг гэдгийг алхам тутамдаа анхаарч байх хэрэгтэй
3. Лифтийн хувьд чиглүүлэгч зам төмрийг маш тэгш тавих ёстой. Зам төмрийг тэгш тавина гэдэг нь барилгын суурийг тэгш тавихтай адилтган ойлгож болно
4. Электрон системийн холболтыг хийхдээ түүний бүх хөлийг тестрээр хэмжиж байх ёстой хүчдэл гүйдэл байгаа эсэхийг нягтлана

Хариу 4

**17. Угсралт чанартай байхын тулд чиглүүлэгч зам төмрийг тавихад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Лифтийн хувьд чиглүүлэгч зам төмрийг маш тэгш тавих ёстой. Зам төмрийг тэгш тавина гэдэг нь барилгын суурийг тэгш тавихтай адилтган ойлгож болно
2. Түүний хоорондох зай өндрийн туршид ижил байхаас гадна эгц босоо байдал, өөд өөдөөсөө харсан байдал алдаагүй байх ёстой. Үүнийг чанартай гүйцэтгэхэд хэмжих багаж маш чухал
3. Нэг зам төмөрт 5-6 тогтоогч /кронштейн/ таарч байхаар хийнэ. Гэхдээ энэ нь замын залгаас дээр таарч болохгүй
4. Бас зам тавьсны дараа хяналтын алба /чанар шалгагч/ түүнийг тусгайлан шалгаж хүлээн авдаг байх шаардлагатай. Тэд ажлаа дүүжин утасны тэгш татсан эсэхийг шалгахаас эхлэнэ.

Хариу 3

**18. Угсралт чанартай байхын тулд чиглүүлэгч зам төмрийг тавихад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Лифтийн хувьд чиглүүлэгч зам төмрийг маш тэгш тавих ёстой. Зам төмрийг тэгш тавина гэдэг нь барилгын суурийг тэгш тавихтай адилтган ойлгож болно
2. Түүний хоорондох зай өндрийн туршид ижил байхаас гадна эгц босоо байдал, өөд өөдөөсөө харсан байдал алдаагүй байх ёстой. Үүнийг чанартай гүйцэтгэхэд хэмжих багаж маш чухал
3. Зам төмрийн урт хонгилын уртад яг таарсан байх ёстой
4. Бас зам тавьсны дараа хяналтын алба /чанар шалгагч/ түүнийг тусгайлан шалгаж хүлээн авдаг байх шаардлагатай. Тэд ажлаа дүүжин утасны тэгш татсан эсэхийг шалгахаас эхлэнэ

Хариу 3

**19. Угсралт чанартай байхын тулд хөтлүүрийг суурилуулахад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хөтлүүрийн үндсэн болон чиглүүлэгч шкивээс бүхээг, эсрэг ачааны орой дээр ирж холбогдож байгаа ган татлага төвөө олсон, эгц босоо байх шаардлагатай. Үүнийг дүүжин утасны тусламжтайгаар хэмжинэ
2. Хөтлүүр чиглүүлэгч шкивын хоорондох зайг тэдгээрээс бууж байгаа ган татлага нүхнийхээ төвөөр бууж байхаар тааруулна. Үүнийг мөн сунадаг метрийн тусламжтайгаар хэмжинэ

3. Үндсэн болон чиглүүлэгч шкив нэг шулууны дагуу байхаар хөтлүүр, чиглүүлэгч шкив тавигдсан байх ёстой. Үүнийг мөн дүүжин утасны тусламжтайгаар хэмжинэ
4. Хөтлүүрийн доод, дээд суурь хөндлөн болон дагуу чиглэлдээ хэвтээ гадаргуутай параллель суурилсан байх ёстой. Үүнийг тэгш усны тусламжтай хэмждэг

Хариу 2

**20. Угсралт чанартай байхын тулд хөтлүүр суурилуулахад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хөтлүүрийн үндсэн болон чиглүүлэгч шкивээс бүхээг, эсрэг ачааны орой дээр ирж холбогдож байгаа ган татлага төвөө олсон, эгц босоо байх шаардлагатай. Үүнийг дүүжин утасны тусламжтайгаар хэмжинэ
2. Үндсэн болон чиглүүлэгч шкив эгц босоо байхаар хөтлүүр тавигдсан байх ёстой. Үүнийг мөн дүүжин утасны тусламжтайгаар хэмжинэ
3. Хөтлүүр суурилах өндөр нь машины өрөөний дэгээнээс 1м-ээс багагүй зайд байхаар тааруулна. Үүнийг метрээр хэмжинэ
4. Үндсэн болон чиглүүлэгч шкив нэг шулууны дагуу байхаар хөтлүүр, чиглүүлэгч шкив тавигдсан байх ёстой. Үүнийг мөн дүүжин утасны тусламжтайгаар хэмжинэ
5. Хөтлүүрийн доод, дээд суурь хөндлөн болон дагуу чиглэлдээ хэвтээ гадаргуутай параллель суурилсан байх ёстой. Үүнийг тэгш усны тусламжтай хэмждэг

Хариу 3

**21. Угсралт чанартай байхын тулд хурд хязгаарлагчийг суурилуулахад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хурд хязгаарлагчийг зааварт зааснаар түүнийг төвөөс зугатах ачаа байрлах тал руу нь 30 градусаар хазайж байхаар байрлуулна
2. Хурд хязгаарлагчийн ган татлага нь эгц босоо, чиглүүлэгч зам төмөртэй параллель байхаар хурд хязгаарлагч, түүний татлага чангалагчийг байрлуулна. Үүний тулд эхлээд хурд хязгаарлагчаас баригчийн татуурга дээр бэхлэгдэж байгаа ган татлага эгц босоо буух ёстой. Үүнийг дүүжин чиг утасны тусламжтай гүйцэтгэнэ
3. Хурд хязгаарлагчийн болон татлага чангалагчийн шкив эгц босоо байхаар хурд хязгаарлагч болон түүний татлага чангалагчийг суурилуулсан байна. Үүнийг дүүжин чиг утасны тусламжтай гүйцэтгэнэ
4. Хурд хязгаарлагчийн ган татлагыг бэхлэхдээ хагас өдрөөс доошгүй хугацаагаар түүнийг унжуулж амрах шаардлагатай. Учир нь бүрэн эрч нь гараагүй ган татлага шкивээр өнгөрөх бүрдээ мушгирах хөдөлгөөн хийж түүний элэгдлийг ихэсгэдэг

Хариу 1

**22. Угсралт чанартай байхын тулд хурд хязгаарлагчийг суурилуулахад дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хурд хязгаарлагчийн ган татлага нь эгц босоо, чиглүүлэгч зам төмөртэй параллель байхаар хурд хязгаарлагч, түүний татлага чангалагчийг байрлуулна. Үүний тулд эхлээд хурд хязгаарлагчаас баригчийн татуурга дээр бэхлэгдэж байгаа ган татлага эгц босоо буух ёстой. Үүнийг дүүжин чиг утасны тусламжтай гүйцэтгэнэ
2. Хурд хязгаарлагчийн болон татлага чангалагчийн шкив эгц босоо байхаар хурд хязгаарлагч болон түүний татлага чангалагчийг суурилуулсан байна. Үүнийг дүүжин чиг утасны тусламжтай гүйцэтгэнэ
3. Хурд хязгаарлагчийн татлага чангалагчийн ачааг газар шүргэхээргүйгээр байрлуулна

4. Хурд хязгаарлагчийн ган татлагыг бэхлэхдээ хагас өдрөөс доошгүй хугацаагаар түүнийг унжуулж амрах шаардлагатай. Учир нь бүрэн эрч нь гараагүй ган татлага шкивээр өнгөрөх бүрдээ мушгирах хөдөлгөөн хийж түүний элэгдлийг ихэсгэдэг

Хариу 3

**23. Угсралт чанартай байхын тулд бүхээг угсрахдаа дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Бүхээг, эсрэг ачааны рам алдаагүй тэгш өнцгөөр угсрагдсан байх шаардлагатай. Рамны тэгш өнцөгт алдагдсанаар башмак чиглүүлэгч зам төмөр дээр тэгш бус даралт өгдөг, баригчийн суулт жигд бус болдог, башмак, баригчийн зам төмөртэй харьцах гадаргуу бас ижил бус болдог
2. Бүхээг, хаалга, хаалганы механизмыг тэгш, хана нь нэгэн хавтгайд, харилцан тэгш өнцөг үүсгэсэн байдалтай угсрах нь зөвхөн үзэмжтэй харагдахдаа биш хаалганы ажиллагаа гажаагүй байх, бүхээг дуу чимээгүй байхад нөлөөлдөг
3. Хонгилын хаалганы босгыг тэгш угсраад хөдөлгөөнгүй бэхэлж өгнө. Босго хэвтээ гадаргуутай хөндлөн дагуу чиглэлдээ параллель байхаас гадна хэмжилтийн чиг барих босоо дүүжин утаснаас ижил зайд алдаагүй тавигдсан байх шаардлагатай
4. Бүхээгний шалны контактыг дарагчаас нь 1см-н зайтай байрлуулж бэхэлгээг найдвартай хийсэн байна

Хариу 4

**24. Угсралт чанартай байхын тулд үйл ажиллагаандаа дараах зүйлсийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Энд алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Тухайн лифт угсардаг байгууллага нь өөртөө угсрах ажлын чанарыг шалгах системийг бий болгосон байх шаардлагатай байдаг
2. Аливаа хоёр эд ангийг хооронд нь угсарч бооход заавал ямар нэг хэмжилт хийгддэг гэдгийг алхам тутамдаа анхаарч байх хэрэгтэй
3. Лифтийн хувьд чиглүүлэгч зам төмрийг маш тэгш тавих ёстой. Зам төмрийг тэгш тавина гэдэг нь барилгын суурийг тэгш тавихтай адилтган ойлгож болно
4. Баригчийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэж лацадсан байх шаардлагатай
5. Хөтлүүрийг зөв суурилуулах асуудал бас чухал байр суурийг эзэлдэг
6. Бүхээг, эсрэг ачааны рам алдаагүй тэгш өнцгөөр угсрагдсан байх шаардлагатай

Хариу 4

**25. Зарим эд ангийн угсралтын чанарын нөлөөллийг хаана буруу бичсэн байна вэ?**

1. Зам төмрийг тэгш тавьснаар бүхээг шилжихэд үүсэх дуу чимээ, чичиргээ, савалгаа мэдэгдэхгүй болж улмаар башмак, баригч, бүхээгтэй холбоотой мэдрэгчүүдийн найдварт ажиллагаа сайжирдаг
2. Эсрэг ачааг тэгш угсарснаар зам төмөр дээр элдэв дуу чихраа үүсэхгүй, зам төмөр, гулгааны эдэлгээ удааширдаг
3. Хөтлүүрийг тэгш тавиагүйгээс болж үндсэн болон чиглүүлэгч шкив, ган татлага элэгдэх, бүхээг эсрэг ачаанаас зам төмөрт нэмэгдэл ачаалал өгч тэдгээрийг элэгдүүлэх, гулзайлгахад муугаар нөлөөлөхөөс гадна ган татлага болон бүхээгнээс үүсэх дуу, чичиргээг нэмэгдүүлдэг. Мөн хөтлүүрийг оруулахад задлахгүй байх шаардлагатай. Учир нь түүнийг эргүүлж угсрахад баланс алдагдах магадлалтай ба энэ нь түүний чичиргээг нэмэгдүүлдэг



4. Хурд хязгаарлагчийг тэгш тавиагүйгээс болж хурд хязгаарлагчийн болон татлага чангалагчийн шкив, ган татлага элэгдэх, ган татлага савлах ба түүнээс үүсэх дуу, чичргээг нэмэгдүүлдэг
5. Рамны тэгш өнцөгт алдагдсанаар башмак чиглүүлэгч зам төмөр дээр тэгш бус даралт өгдөг, баригчийн суулт жигд бус болдог, башмак, баригчийн зам төмөртэй харьцах гадаргуу бас ижил бус болдог. Энэ нь дууг ихэсгэх, дээрх эд ангиудын насжилтыг багасгахад нөлөөлдөг. Бүхээг ажлын хүнд нөхцөлд, байнгын дээш, доош шилжих горимд ажилладаг тул түүний элэгдэл, дуу чимээнд үзүүлэх өчүүхэн бага нөлөөлөл нь ашиглалтын явцад хурдан ихэсдэг
6. Бүхээг, хаалга, хаалганы механизмыг тэгш, хана нь нэгэн хавтгайд, харилцан тэгш өнцөг үүсгэсэн байдалтай угсрах нь зөвхөн үзэмжтэй харагдахдаа биш хаалганы ажиллагаа гажаагүй байх, бүхээг дуу чимээгүй байхад нөлөөлдөг

Хариу 2

**26. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Зам төмрийг бүгдийг оруулж тавих
2. Замын бэхэлгээ хийнэ
3. Чиг угас татах
4. Зам угсрах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**27. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Шат угсрах
2. Чиг угас татах
3. Дүүжин кабель байрлуулах
4. Бүхээгний рам угсрах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**28. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Хаалганы хэмжилт хийнэ
2. Хонгилын хаалганы рам угсрах
3. Хонгилын хаалганы самбар угсрах
4. Хонгилын хаалганы рамыг хонгилд угсрах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**29. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Машины өрөөнд тоног төхөөрөмжүүдийг оруулах
2. Дүүжин кабель байрлуулах
3. Машины өрөөний шитэнд дүүжин кабель, дуудлагын аппаратны, утсыг холбох

4. Цахилгааны щит суурилуулах
5. Цахилгааны утас татах суваг байрлуулах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**30. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Хонгилын хаалганы самбар угсрах
2. Шат буулгах
3. Машины өрөөний шитэнд дүүжин кабель, дуудлагын аппаратны, утсыг холбох
4. Худагт буфер угсрах
5. Үндсэн татлага сүвлэх

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**31. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Шат буулгах
2. Хонгилын багц утас оруулах
3. Хонгил, худагт хийх холболт
4. Худагт буфер угсрах
5. Лифтийг бага хурдаар ажиллуулах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**32. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Хонгил, худагт хийх холболт
2. Бүхээгний цахилгаан холболт хийх
3. Лифтийг бага хурдаар ажиллуулах
4. Цахилгааны бүх холболтыг шалгах

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж

Хариу 2

**33. Лифтийн зарим эд ангийг угсрах дараалал**

1. Дутуу зүйлсийг угсрах
2. Хэвийн горимоор ажиллуулах
3. Лифтийг бага хурдаар ажиллуулах
4. Нарийвчлан тохиргоо хийж шалгах
5. Туршиж хүлээлгэж өгнө

Энд дарааллыг зөв бичиж чадсан байна уу?

1. Зөв бичиж
2. Буруу бичиж



Хариу 2

**34. Ерөнхий хэмжилтээр лифтийг тухайн барилгын хонгилд угсрахад тохирох эсэхийг хэмжиж тогтоох ба энд дараах ажлуудаас аль нь хамаарахгүй вэ?**

1. Хонгилын өргөн, урт, өндрийн хэмжээ зурагт заасан хэмжээтэй тохирч байгаа эсэх
2. Хонгилын хөндлөн огтлолын диагналийн хэмжээнүүд тэнцүү байгаа эсэх
3. Эсрэг ачааны суух хэмжээс зургийн дагуу байгаа эсэх
4. Давхар бүрийн хонгилын хаалганы нүхний босоо тэнхлэг нэг босоо шугам дээр таарч, хаалгануудын босгонууд параллель байгаа эсэх
5. Машины өрөөний тросс орох нүхний байрлал зурагт заасан хэмжээтэй тохирч байгаа эсэхийг тус тус хэмжиж шалгана
6. Машины өрөөний шалны даац лифтийн хөтлүүрийг дааж чадах эсэх

Хариу 6

**35. Шатны хоёр тавцангийн хоорондох зай нь**

1. 140-170 см-ын хооронд байна
2. 170-180 см-ын хооронд байна
3. 200-220 см-ын хооронд байна

Хариу 2

**36. Хонгилд хэмжилт хийх үед түүний хаалганууд өндрийн дагуу нэг босоо шугамд байгаа эсэхийг шалгахад нэг хаалганд түүнээс чиг утас хүртэл хэдэн хэмжилт хийх вэ?**

1. 2
2. 4
3. 6-аас доошгүй

Хариу 2

**37. Зам төмрөө угсархаас өмнө тэдгээрийг худагт оруулж босоогоор байрлуулна. Үүний тулд дараах зүйлсийг анхаарна: Энд аль нь буруу бичигдсэн байна?**

1. Зам төмрийн төгсгөлийн хамгаалалтыг авч болохгүй
2. Зам төмрийн ховилтой хэсгийг нэг тийш нь харуулж байрлуулна
3. Зам төмрийг өргөхөд угсарсан хэсэгтэй тээглэхгүй байхаар хувааж байрлуулна
4. Хамгийн дээр тавигдах зам төмрийг хэмжээгээр нь тааруулж тайраад оруулна

Хариу 4

**38. Шкивны татлага суух ховилын төв доошоо орох нүхний төвтэй давхцаж байгаа эсэхийг утас унжуулж шалгана. Алдаа нь:**

1. 0,02 мм-с ихгүй
2. 0,5 мм-с ихгүй
3. 5 мм-с ихгүй

Хариу 2

**39. Шкивүүд босоо тэнхлэгийн дагуу байгаа эсэхийг шкивний дээд ирмэгний хавиас ачаа дүүжилж үзэж шалгана. Алдаа нь:**

1. 0,5 мм-с ихгүй
2. 1,5 мм-с ихгүй
3. 2,5 мм-с ихгүй
4. 3,5 мм-с ихгүй

Хариу 1

**40. Хоёр шкив нэг шулууны дагуу байрласан эсэхийг хоёр шкивний дагуу утас татаж шкивний хажуу гадаргуу утасны хооронд завсар гарч байгаа эсэхийг хоёр талд нь хэмжиж үзнэ.**

**Алдаа нь аль хэмжээнээс хэтэрч болохгүй вэ?**

1. 0,05 мм-с ихгүй
2. 0,5 мм-с ихгүй
4. 4 мм-с ихгүй

Хариу 2

**41. Бүхээгний болон эсрэг ачааны замыг зэрэг угсарч**

1. Болно
2. Болохгүй

Хариу 1

**42. Хамгийн дээд талын зам төмөр хонгилын таазнаас хэдэн см дотогш байх вэ?**

1. 2 см-с ихгүй
2. 4 см-с ихгүй
3. 5 см-с ихгүй
4. 5 см-с багагүй

Хариу 4

**43. Эсрэг ачааны рамьг угсрахдаа дор нь модон тулгуур хийдэг нь ямар учиртай вэ?**

1. Түүнийг санамсаргүй байдлаар унахаас хамгаалж
2. Түүнийг зөөлөн тулгууртай байлгах гэж
3. Эсрэг ачааг рамд нь оруулахад хялбар байлгах гэж
4. Бүхээг угсрахад эсрэг ачаа буфер хоёрын зайг тохируулах гэж

Хариу 4

**44. Хонгилд байх суурин тоноглолуудыг цахилгаанаар тэжээх багц утаснаас дараахь хэсэг рүү салбарлуулан хонгилын хананд бэхэлнэ. Энд аль нь буруу бичигдсэн байна вэ?**

1. Хамгийн дээд, доод хязгаарын таслагчийн утсыг
2. Дуудлагын аппаратны утас
3. Хаалганы түгжээ, бусад таслагчуудын утас
4. Худагт хурд хязгаарлагчийн тросс чангалагчийн таслагч, худгийн гэрэл, хонх, стоп товчлууур, розетка, галын аваарын товчлуурыг холбох утасны багц
5. Хонгилын гэрэлтүүлгийн чийдэнгүүдэд

Хариу 5

**45. Хурд хязгаарлагчийн ган татлагын үзүүрийг юунд бэхэлдэг вэ?**

1. Үндсэн ган татлагад
2. Бүхээгний ирмэгт
3. Баригчийн татуурганд
4. Бүхээгний босгонд
5. Давхрын таслагчид

Хариу 3

**46. Хаалганы самбар хаалттай үедээ рамны цаагуур хэдэн мм зөрж орсон байх вэ?**

1. Зөрж орохгүй байх ёстой
2. 5 мм
3. 12 мм
4. 20 мм-с дээш

Хариу 3

47. Цахилгааны холболт хийхдээ моторт хэдэн вольтын хүчдэл өгөх вэ?

1. 24В
2. 220В
3. 380В
4. 600В

Хариу 3

48. Цахилгааны холболт хийхдээ хонгилын гэрэлтүүлэгт хэдэн вольтын хүчдэл өгөх вэ?

1. 24В
2. 220В
3. 380В
4. 600В

Хариу 2

49. Цахилгааны холболт хийхдээ удирдлагын хэлхээнд хэдэн вольтын хүчдэл өгөх вэ?

1. 24В
2. 220В
3. 380В
4. 600В

Хариу 1

50. Лифтийг бага хурдаар ажиллуулж шалгахын өмнө дараахь ажлууд хийгдсэн байна. Дор ямар ажлыг илүү бичсэн байна вэ?

1. Лифтийн механик хэсгийг бүрэн угсарсан байна
2. Лифтийн цахилгааны хэсгийг бүрэн угсарсан байна
3. Бүхээгний доод, босгоны, хаалганы механизмуудын хаалтуудыг бүрэн угсарсан байна
4. Цахилгааны холболтыг схемн дагуу дахин нягталж шалгасан байна

Хариу 3

51. Лифтийг бага хурдаар ажиллуулсны дараа хэвийн горимоор ажиллуулахын өмнө хийдэг ажлуудаас ямар ажлыг илүү бичсэн байна вэ?

1. Хонгилын хаалганы тохиргоог нягтлан хийнэ
2. Лифтийн давхрын мэдрэгчүүдийн байрлалыг дахин тохируулна
3. Хонгилын эцсийн таслагчуудын байрлалыг дахин нягтлана
4. Бүхээгний агааржуулалтын сэнсны ажиллагааг шалгана

Хариу 4

52. Чиг утасны хэвийг хийхэд угсралтын зурагнаас хэрэглэх хэмжээсүүдээс алийг нь буруу бичсэн байна вэ?

1. Хонгилын өргөн
2. Бүхээгний зам төмрийн хоорондох зай
3. Эсрэг ачааны зам төмрийн хоорондох зай
4. Бүхээгний 2 зам төмөр, эсрэг ачааны 2 зам төмрийг холбосон тэнхлэгүүдийн хоорондох зай
5. Бүхээгний 2 зам төмрийг холбосон тэнхлэг, бүхээгний босгоны гадна ирмэг хүртлэх зай
6. Хаалганы өргөн

Хариу 1

**53. Чиг утасны хэвийг хийхэд угсралтын зурагнаас хэрэглэх хэмжээсүүдээс алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хонгилын гүн
2. Бүхээгний зам төмрийн хоорондох зай
3. Эсрэг ачааны зам төмрийн хоорондох зай
4. Бүхээгний 2 зам төмөр эсрэг ачааны 2 зам төмрийг холбосон тэнхлэгүүдийн хоорондох зай
5. Бүхээгний 2 зам төмрийг холбосон тэнхлэг, бүхээгний босгоны гадна ирмэг хүртлэх зай
6. Хаалганы өргөн

Хариу 1

**54. Чиг утасны хэвийг хийхэд угсралтын зурагнаас хэрэглэх хэмжээсүүдээс алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хонгилын өндөр
2. Бүхээгний зам төмрийн хоорондох зай
3. Эсрэг ачааны зам төмрийн хоорондох зай
4. Бүхээгний 2 зам төмөр эсрэг ачааны 2 зам төмрийг холбосон тэнхлэгүүдийн хоорондох зай
5. Бүхээгний 2 зам төмрийг холбосон тэнхлэг, бүхээгний босгоны гадна ирмэг хүртлэх зай
6. Хаалганы өргөн

Хариу 1

**55. Чиг утасны хэвийг хийхэд угсралтын зурагнаас хэрэглэх хэмжээсүүдээс алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хонгилын хаалганы өндөр
2. Бүхээгний зам төмрийн хоорондох зай
3. Эсрэг ачааны зам төмрийн хоорондох зай
4. Бүхээгний 2 зам төмөр, эсрэг ачааны 2 зам төмрийг холбосон тэнхлэгүүдийн хоорондох зай
5. Бүхээгний 2 зам төмрийг холбосон тэнхлэг, бүхээгний босгоны гадна ирмэг хүртлэх зай
6. Хаалганы өргөн

Хариу 1

**56. Чиг утасны хэвийг хийхэд угсралтын зурагнаас хэрэглэх хэмжээсүүдээс алийг нь буруу бичсэн байна вэ?**

1. Хонгилын хаалганаас хажуу хана хүртлэх зай
2. Бүхээгний зам төмрийн хоорондох зай
3. Эсрэг ачааны зам төмрийн хоорондох зай
4. Бүхээгний 2 зам төмөр, эсрэг ачааны 2 зам төмрийг холбосон тэнхлэгүүдийн хоорондох зай
5. Бүхээгний 2 зам төмрийг холбосон тэнхлэг, бүхээгний босгоны гадна ирмэг хүртлэх зай
6. Хаалганы өргөн

Хариу 1